



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/542

Булган сум

Г Дэмжлэг үзүүлэх тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны "Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай" XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Франц улсын нийслэл Парис хотноо зохион байгуулагдах "Парис-2024" зуны олимпын наадамд Бөөрөнцөг түлхэлтийн төрлөөр оролцох тамирчин Ц.Баттулга, чөлөөт бөхийн төрлөөр оролцох тамирчин Б.Бат-Эрдэнэ нарт байр, хоолны зардалд тус бүр 5,000,000 (таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлыг Булган аймаг, Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2024 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд тусгагдсан аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

8324010721